

ХӨВСГӨЛ АЙМАГ

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД БИЕ
ДААН НЭР ДЭВШИГЧ САЙНБАЯРЫН МӨНХ-ЭРДЭНИЙН МӨРИЙН
ХӨТӨЛБӨР**

/ 2020-2024 /



2020.07.23

Two handwritten signatures in black ink, positioned below the date. The signatures are stylized and appear to be written by different individuals. The first signature is on the left and the second is on the right.

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ:

Нэр дэвшигч миний бие энэхүү мөрийн хөтөлбөрийг боловсруулахдаа Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” хөгжлийн бодлого, УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, 2001 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, Хөвсгөл аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2015 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Хөвсгөл аймгийн нийгэм, эдийн засгийг 2016-2030 онд хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөр” зэрэг баримт бичгүүдэд дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль болон мөн хуулийн 37 дугаар зүйлийн хэсэгт нийцүүлэн боловсрууллаа.

ЗОРИЛГО:

Монгол улсын эдийн засгийн тулгуур баганууд болох аялал жуулчлал, мал аж ахуйн төв бүс нутаг болох Хөвсгөл аймгийнхаа хөгжлийг сайжруулах, иргэдийн амьдралын баталгаа, чанарыг дээшлүүлэхэд бодитой дэмжлэг болоход энэхүү мөрийн хөтөлбөрийн зорилго оршино.

УРИА: ХӨГЖИЛ, ШИНЭЧЛЭЛИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА

I. БОЛОВСРОЛТОЙ, ОРОЛЦООТОЙ ИРГЭН ХӨГЖЛИЙН ТҮЛХҮҮР

1. Иргэдийн амьдрах арга ухаан, улс төр, санхүүгийн боловсролыг дээшлүүлэх орон нутгийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
2. Ерөнхий боловсролын сургуулиудын сургуулийн мэдлийн цагийн агуулгад хувь хүний хөгжил, хувийн зохион байгуулалтын агуулгыг тусгах боломжийг орон нутгийн мэргэжлийн байгууллагатай хамтран судалж хэрэгжүүлнэ.
3. Аялал жуулчлалын бүс нутгийн хувьд давын өмнө үйлчилгээний бизнес эрхлэгчдийн англи хэлний чадварыг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж ажиллана.



II. ШУДАРГА, ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ ЗАСАГЛАЛ ХӨГЖЛИЙН БАТАЛГАА

1. Сум хөгжүүлэх сан, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн зээлүүдийг ил, тод шударгаар хуваарилж баялаг бүтээгчдийг бодитоор дэмжих дуу хоолой болж ажиллана.
2. Төсвийн зарцуулалт, худалдан авалт, тендэрийн үйл ажиллагааны шударга, ил тод, нээлттэй байдалд холбогдох хууль, журмын хүрээнд хяналт, шаардлага тавьж ажиллана.
3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө зарцуулах үйл ажиллагааг журмын дагуу шударгаар зохион байгуулж, бүтээн байгуулалтыг чанартай хийлгэнэ.
4. Төрийн албаны үйлчилгээний чанар, хүртээмийг дээшлүүлэх “Экспресс үйлчилгээ” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

III. ЭРҮҮЛ, ТОХИЛОГ ХОТ АМАР ТАЙВАН АМЬДРАЛЫН ҮНДЭС

1. Мөрөн хотын айл өрхүүдэд дулаан, цэвэр, бохир усны инженерийн шугам сүлжээнд холбогдохын ач тусыг сурталчилан таниулж, иргэд болон төр, хувийн хэвшлийн байгууллагуудын ойлголцол, хамтын түншлэлд тулгуурлан шугам сүлжээнд үе шаттай холбох, дулааны алдагдалгүй эко сууц барих технологи нэвтрүүлэх замаар хөрс, агаарын бохирдлыг бууруулахад бодлого, үйл ажиллагаагаа чиглүүлж тууштай ажиллана.
2. Мөрөн хотын иргэдийг орон сууцжуулах бодлогыг тууштай дэмжиж, үйл ажиллагааг эрчимжүүлэхэд анхаарч ажиллана.
3. Иргэд, залуучуудын санаачилга, оролцоонд тулгуурлан төр, хувийн хэвшлийнхний дэмжлэгтэйгээр хүүхэд, залуус чөлөөт цагаа өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэн байгуулах, гэр хорооллын ногоон байгууламжийг сайжруулахад идэвх, санаачилга гарган ажиллана.
4. Мөрөн хотын ус зайлуулах хоолой, үерийн усны даланг засч сайжруулах, шинээр баригдах авто замын ТЭЗҮ-д ус зайлуулах шугам тусгах асуудлыг хөндөж, орон нутгийн бодлогод тусгуулна.



144193
32 907080

IV. АЖИЛ, ОРЛОГОТой ЧИНЭЭЛЭГ АЙМАГ

1. Аймгийн хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст түшиглэсэн цагийн ажилд зуучлах цэг байгуулж, ажил олгогч, ажилтнуудыг шуурхай холбох боломж бүрдүүлнэ.
2. Хамгаалагдсан хөрсний аж ахуй буюу хүлэмжийн нарийн ногооны тариалалтыг нэмэгдүүлж өргөст хэмх, улаан лооль, брокколи байцаа, салат навч зэрэг эрүүл хүнсний бүтээгдэхүүнүүдийн зах зээл дэх нийлүүлэлтийг нэмэгдүүлж, импортын хамаарлыг бууруулна.
3. Мах, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулах, орон нутгийн брэнд бүтээгдэхүүнүүдийн нэр төрлийг олшруулах бодлогыг тууштай дэмжиж ажиллана.
4. Мөрөн хотод жуулчны гудамж байгуулах санаачилга гаргаж, гадаад, дотоодын жуулчдад зориулсан худалдаа, үйлчилгээ, эвент арга хэмжээ бий болгоно.
5. Хөгжимт Драммын Театрын үйл ажиллагаа, менежментийг сайжруулж, Хөвсгөл аймагт ирж буй гадаад, дотоодын жуулчид, иргэдэд зориулсан 7 хоногийн тогтсон хөтөлбөр бүхий урлаг, соёлын үйлчилгээг нэвтрүүлэх замаар урлаг, соёлын ажилтнуудын амьдралын чанарыг дээшлүүлэх боломжийг судалж хэрэгжүүлнэ.

Мерийн хөтөлбөр боловсруулсан:

Бие даан нэр дэвшигч



Сайнбаярын Мөнх-Эрдэнэ

Утас: 92033366

Email: Munkherdene.sainbayar@gmail.com

Гэрийн хаяг: Мөрөн сумын 10-р багийн 39-р

гудамжны 20 тоот.

